



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар A/82

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Капитал банк” ХХК (52556375)-ийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг (Хэрлэн), Тэмүүжин гудамжинд байрлах, үйлчилгээний зориулалттай 1988 м² газрыг “Монгол банк” (5465176)-д 37 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.“Монгол банк”-ны эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-т үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг “Монгол банк”-ны ерөнхийлөгч (Б.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/554 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

